НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангӣ тайлан

**Аудитын код:** НТАГ-2024/01/НА-СТА-ТӨА

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Г.Долгорсүрн<br>Утас: 325093 Цахим хаяг: dolgorsureng@audit.gov.mn<br><br>Аудитор: Ш.Мөнхжаргал<br>Утас: 325093 Цахим хаяг: Munkhjargalsh@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 622

танай ______-ны №______-т

НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨХК-ИЙН ДАРГА Ц.ЭНХТҮВШИН
ТАНАА

# АУДИТЫН ДҮГНЭЛТ

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

D:\Desktop\2024\Word\Явсан бичиг\2024.03.15.Nalaihin.dulaanii.stants.docx

002022165

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

D:\Desktop\2024\Word\Явсан бичиг\2024.03.15.Nalaihin.dulaanii.stants.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | **0.00** | **0.00** |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | **0.00** | **0.00** |
| 1.1.01 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 69,878,392.94 | 19,197,864.22 |
| 1.1.02 | Дансны авлага | 343,875,149.39 | 493,309,414.68 |
| 1.1.03 | Татвар, НДШ-ийн авлага | 37,023,384.00 | 34,039,090.53 |
| 1.1.04 | Бусад авлага | 0.00 | 0.00 |
| 1.1.05 | Бусад санхүүгийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.06 | Бараа материал | 354,180,323.01 | 386,088,374.06 |
| 1.1.07 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 0.00 | 0.00 |
| **1.1.8** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **804,957,249.34** | **932,634,743.49** |
| | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.01 | Үндсэн хөрөнгө | 8,372,488,228.51 | 8,027,044,163.78 |
| 1.2.02 | Биет бус хөрөнгө | 1,980,791,341.08 | 2,008,833,416.94 |
| 1.2.3 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 10,353,279,569.59 | 10,035,877,580.72 |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **11,158,236,818.93** | **10,968,512,324.21** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **0.00** | **0.00** |
| **2.1** | **Өр төлбөр** | **0.00** | **0.00** |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | 0.00 | 0.00 |
| 2.1.1.01 | Дансны өглөг | 1,050,721,571.65 | 1,468,817,075.83 |
| 2.1.1.02 | Цалингийн өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.03 | Татварын өр | 39,275,121.66 | 328,047,914.21 |
| 2.1.1.04 | НДШ - ийн өглөг | 158,791,050.66 | 0.00 |
| 2.1.1.05 | Богино хугацаат зээл | 0.00 | 0.00 |
| 2.1.1.06 | Хүүний өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.07 | Ногдол ашгийн өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.08 | Урьдчилж орсон орлого | 20,900,909.86 | 50,099,521.48 |
| 2.1.1.09 | Бусад богино хугацаат өр төлбөр | 2,317,135.82 | 0.00 |
| **2.1.1.10** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **1,272,005,789.65** | **1,846,964,511.52** |
| 2.1.2.01 | Урт хугацаат зээл | 0.00 | 0.00 |
| 2.1.2.02 | Бусад урт хугацаат өр төлбөр | 0.00 | 0.00 |
| **2.1.2.03** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **0.00** | **0.00** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **1,272,005,789.65** | **1,846,964,511.52** |
| 2.3 | Эздийн өмч | 0.00 | 0.00 |
| 2.3.01 | Өмч: - төрийн | 8,703,255,561.66 | 8,703,255,561.66 |
| 2.3.02 | - хувийн | 0.00 | 0.00 |
| 2.3.03 | - хувьцаат | 0.00 | 0.00 |
| 2.3.04 | Нэмж төлөгдсөн капитал | 0.00 | 0.00 |
| 2.3.05 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 2,727,654,260.64 | 2,727,654,260.64 |
| 2.3.06 | Эздийн өмчийн бусад хэсэг | 1,952,180,999.37 | 1,952,180,999.37 |
| 2.3.07 | Хуримтлагдсан ашиг | -3,496,859,792.39 | -4,261,543,008.98 |
| 2.3.08 | Эздийн өмчийн дүн | 9,886,231,029.28 | 9,121,547,812.69 |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **11,158,236,818.93** | **10,968,512,324.21** |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 01 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | 4,104,023,471.12 | 5,075,949,879.45 |
| 02 | **Борлуулалтын өртөг** | 6,002,306,733.62 | 7,776,611,757.87 |
| 03 | **Нийт ашиг( алдагдал)** | -1,898,283,262.50 | -2,700,661,878.42 |
| 04 | Түрээсийн орлого | 2,945,454.60 | 1,963,636.40 |
| 05 | Хүүний орлого | - | 445,530.16 |
| 06 | Ногдол ашгийн орлого | - | - |
| 07 | Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| 08 | Бусад орлого | 143,689,256.91 | 217,044,918.19 |
| 09 | Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 193,840,263.39 | 256,272,923.62 |
| 11 | Санхүүгийн зардал | - | - |
| 12 | Бусад зардал | - | - |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | - | - |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - | - |
| 17 | Бусад ашиг ( алдагдал) | 1,379,412,891.31 | 1,972,797,500.70 |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)** | -566,075,923.07 | -764,683,216.59 |
| 19 | Орлогын татварын зардал | - | - |
| 20 | **Татварын дараах ашиг (алдагдал)** | -566,075,923.07 | -764,683,216.59 |
| 21 | Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал) | - | - |
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | -566,075,923.07 | -764,683,216.59 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 23.3 | Бусад олз (гарз) | - | - |
| 24 | Орлогын нийт дүн | -566,075,923.07 | -764,683,216.59 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | |
| 01 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | 4,104,023,471.12 | 5,075,949,879.45 |
| 02 | **Борлуулалтын өртөг** | 6,002,306,733.62 | 7,776,611,757.87 |
| 03 | **Нийт ашиг( алдагдал)** | -1,898,283,262.50 | -2,700,661,878.42 |
| 04 | Түрээсийн орлого | 2,945,454.60 | 1,963,636.40 |
| 05 | Хүүний орлого | - | 445,530.16 |
| 06 | Ногдол ашгийн орлого | - | - |
| 07 | Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| 08 | Бусад орлого | 143,689,256.91 | 217,044,918.19 |
| 09 | Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 193,840,263.39 | 256,272,923.62 |
| 11 | Санхүүгийн зардал | - | - |
| 12 | Бусад зардал | - | - |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | - | - |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - | - |
| 17 | Бусад ашиг ( алдагдал) | 1,379,412,891.31 | 1,972,797,500.70 |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)** | -566,075,923.07 | -764,683,216.59 |
| 19 | Орлогын татварын зардал | - | - |
| 20 | **Татварын дараах ашиг (алдагдал)** | -566,075,923.07 | -764,683,216.59 |
| 21 | Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал) | - | - |
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | -566,075,923.07 | -764,683,216.59 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 23.3 | Бусад олз (гарз) | - | - |
| 24 | Орлогын нийт дүн | -566,075,923.07 | -764,683,216.59 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 01 | **2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл** | **8,534,873,748.12** | **2,727,654,260.64** | **1,988,815,812.91** | **-2,930,783,869.32** | **10,320,559,952.35** |
| 04 | Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | 00.00 | 00.00 | 00.00 | -566,075,923.07 | -566,075,923.07 |
| 05 | Өмчит гарсан өөрчлөлт | 168,381,813.54 | 0.00 | -36,634,813.54 | 0.00 | 131,747,000.00 |
| 06 | **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **8,703,255,561.66** | **2,727,654,260.64** | **1,952,180,999.37** | **3,496,859,792.39** | **9,886,231,029.28** |
| 07 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 09 | Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | 00.00 | 00.00 | 00.00 | -764,683,216.59 | -764,683,216.59 |
| 10 | Өмчид гарсан өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 12 | **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **8,703,255,561.66** | **2,727,654,260.64** | **1,952,180,999.37** | **4,261,543,008.98** | **9,121,547,812.69** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | - | - |
| 1.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | **6,555,329,415.98** | **8,011,248,267.76** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 4,859,906,867.98 | 5,592,464,182.77 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 349,259.00 | 223,047.00 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 2,775,289.00 | 8,936,081.00 |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | - | - |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 1,650,000,000.00 | 2,355,000,000.00 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 42,298,000.00 | 54,624,956.99 |
| 1.2 | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **6,417,292,437.96** | **8,005,313,291.38** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 1,674,481,257.70 | 2,471,306,342.23 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 548,512,945.93 | 926,147,790.05 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 173,229,988.30 | 316,049,865.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 1,045,997,623.50 | 1,926,433,706.04 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн | 2,048,710,429.57 | 1,585,575,769.25 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | - | - |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 618,924,446.94 | 279,703,926.43 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | - | 2,132,870.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 307,435,746.02 | 497,963,022.38 |
| 1.3 | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **138,036,978.02** | **5,934,976.38** |
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **-** | **-** |
| 2.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | - | **350,294.90** |
| 2.1.2 | Хүлээн авсан хүүний орлого | - | 350,294.90 |
| 2.2 | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **143,456,129.00** | **56,965,800.00** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 123,656,129.00 | 56,965,800.00 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 19,800,000.00 | - |
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-143,456,129.00** | **-56,615,505.10** |
| 3 | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 3.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | - | - |
| 3.2 | **Мөнгөн зарлагын дүн (-)** | - | - |
| 3.2.1 | Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | - | - |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | - | - |
| 3.3 | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | - | - |
| 4 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **-5,419,150.98** | **-50,680,528.72** |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **75,297,543.92** | **69,878,392.94** |
| 6 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **69,878,392.94** | **19,197,864.22** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/мянган төгрөгөөр/*

| **д/д** | **Үзүүлэлт** | **2022 оны гүйцэтгэл** | **2023 оны** | | **Харьцуулалт** | |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | | | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **зөрүү** | **хувь** |
| | Дулаан үйлдвэрлэлт | 97.4 | 98.0 | 97.8 | 0.2 | 99.80 |
| 2 | Нийт орлого | 4,250,658.2 | 5,566,009.2 | 5,295,404.0 | 270,605.20 | 95.14 |
| | Үүнээс: Цэвэр борлуулалт | 4,104,023.5 | 5,407,703.1 | 5,075,949.9 | 331,753.20 | 93.87 |
| | Бусад орлого /Маягт, тендер техникийн нөхцөл, үнсний, алданги торгуулийн, угаалгын, засвар үйлчилгээний орлогууд/ | 146,634.7 | 158,306.2 | 219,454.1 | -61,147.90 | 138.63 |
| 3 | Нийт зардал | 6,316,734.1 | 8,364,651.5 | 8,200,996.1 | 163,655.40 | 98.04 |
| | Үүнээс: Удирдлагын зардал | 127,235.8 | 172,501.4 | 167,843.7 | 4,657.70 | 97.30 |
| 4 | Татварын өмнөх ашиг /алдагдал/ | -2,066,075.9 | -2,798,642.3 | -<br>2,905,592.2 | 106,949.90 | 103.82 |
| | Улсын төсвийн татаас | 1,500,000.0 | 2,000,000.0 | 2,140,909.1 | -140,909.10 | 107.05 |
| 5 | Цэвэр ашиг, алдагдал | -566,075.9 | -798,642.3 | -764,683.1 | -33,959.20 | 95.75 |
| 6 | *<u>Төсвийн төлбөрт нийт дүн</u>* | 1,024,349.8 | 1,292,925.4 | 1,763,802.1 | -470,876.70 | 136.42 |
| | а/ ААНОАТатварт | 0.0 | 0.0 | | 0.00 | #DIV/0! |
| | б/ НӨТ | 353,482.2 | 556,600.0 | 745,761.7 | -189,161.70 | 133.99 |
| | в/ НДШ | 548,512.9 | 427,330.1 | 767,356.7 | -340,026.60 | 179.57 |
| | г/ ХАОАТатвар | 211,508.6 | 294,710.4 | 236,033.7 | 58,676.70 | 80.09 |
| | д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар | 14,427.3 | 9,870.1 | 10,345.6 | -475.50 | 104.82 |
| | е/ Тээврийн хэрэгслийн татвар | 696.6 | 529.1 | 499.1 | 30.00 | 94.33 |
| | ж/Бусад татвар /Газрын төлбөрт/ | 2,262.7 | 1,434.7 | 1,394.7 | 40.00 | 97.21 |
| | з/Агаарын бохирдлын төлбөрийн татвар | 4,858.6 | 2,451.0 | 2,410.5 | 40.50 | 98.35 |
| 7 | Төрийн өмчийн ногдол ашигт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.00 | 0.00 |
| 8 | Нийт ажиллагсдын тоо | 121.0 | 121.0 | 113.0 | 8.00 | 93.39 |
| 9 | Нийт цалингийн сан | 2,080,316.9 | 2,947,104.3 | 2,896,171.5 | 50,932.80 | 98.27 |
| 10 | Нэг ажиллагчийн дундаж цалин | 1,432.7 | 2,029.7 | 2,135.8 | -106.10 | 105.23 |
| 11 | Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ | 63,775.7 | 83,814.6 | 82,410.2 | 1,404.40 | 98.32 |
| 12 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | 1.5 | 1.5 | 1.6 | -0.10 | 106.67 |
| 13 | Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ | 143,456.1 | 415,733.5 | 412,237.1 | 3,496.40 | 99.16 |
| 14 | Нийт авлага | 380,898.5 | 332,000.0 | 527,348.5 | -195,348.50 | 158.84 |
| | Үүнээс: Найдваргүй | 0.0 | 0.0 | 0.0 | 0.00 | 0.00 |
| 15 | Нийт өглөг | 1,272,005.8 | 895,500.0 | 1,846,964.5 | -951,464.50 | 206.25 |
| | Үүнээс: Богино хугацаат | 1,272,005.8 | 895,500.0 | 1,846,964.5 | -951,464.50 | 206.25 |
| | Урт хугацаат | 0.0 | 0.0 | 0.0 | 0.2 | 99.80 |

# 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

## 5.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 33,917.5 мянган төгрөгийн алдаа [1] илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз буруу бүртгэсэн. | 1 | 33,917.5 | | | 1 | 33,917.5 | 1 | 33,917.5 | | | | |
| **Дүн** | **1** | **33,917.5** | | | **1** | **33,917.5** | **1** | **33,917.5** | | | | |

Аудитаар нийт 13,511.4 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 7,761.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4560.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалт тоо | Тоо | Дүн |
| Элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй нийт 273 нэр төрлийн 1,129,039.5 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлээгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Тайлант хугацаанд цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг зөрүүтэй шилжүүлсэн. | 1 | 7761.4 | | | 1 | 7761.4 | | | | | | |
| Бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ | 1 | 1190.0 | | | | | 1 | 1190.0 | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хийж данс бүртгэлд тусгасан. | | | | | | | | | | | | |
| Нормын хувцас худалдан авсан болович эд хариуцагчийн бүртгэл хөтлөөгүй, бараа материалыг шууд зарлагдаж данс бүртгэлд тусгасан | 1 | 4560.0 | | | | | 1 | 4560.0 | | | | |
| **Дүн** | **4** | **13,511.4** | | | **1** | **7,761.4** | **3** | **5,750.0** | | | | |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгахад илэрсэн зөрчилд 1 зөвлөмж, бусад хууль тогтоомжийн хүрээнд нийт 1,186,530.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд дараа жилийн зорилтот түвшинг хугацаа хоцроож байршуулсан. | 1 | - | | | | | 1 | - |
| НДС/202301002 дугаартай "Налайх болон бусад уурхайн нүүрс" (10802.9) гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, НДС/202301003 дугаартай "Машин тээврийн хөлс" гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 2 тендерийг 2 удаа зарлаад амжилтгүй болсон тул тухайн үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай 1 болон түүнээс дээш тооны этгээдэд үнийн санал хүргүүлээгүй шууд гэрээ байгуулсан. | 1 | 1,186,530.2 | | | 1 | 1,186,530.2 | | |
| НДС/202301008, НДС/202301007 дугаартай тендерийн шалгаруулалтын баримт бичиг тус бүрт үнэлгээний хорооны гишүүн, иргэний төлөөлөл | 1 | - | | | | | 1 | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Б.Болорцэнгэл 2 удаагийн тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулаагүй нь хууль, журмын заалттай нийцэхгүй байна. | | | | | | | | |
| НДС/202301008 "УДТТ-ийн дулаан, даралтын хэмжүүрүүдийг хяналтын программ хангамжийн хамт угсралт суурилуулалтын ажил хийх" ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер Үнэлгээний хорооны гишүүн, иргэний төлөөлөл А.Ууганчимэгийн А-3 сертификатын хугацаа 2017-2020 онд дууссан нь журмын заалттай нийцэхгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| НДС/202301008 дугаартай тендерийн урилгыг өдөр тутмын сонинд мэдээлээгүй нь хуулийн заалттай нийцэхгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | 5 | - | | | 1 | - | 4 | - |